



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

“Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах”
халдваргүйжүүлэх бодисыг улсын
бүртгэлд бүртгэх журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 41.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам”-ыг нэгдүгээр, “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын улсын бүртгэлийн гэрчилгээний загвар”-ыг хоёрдугаар, “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх ажил үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын тайлан мэдээний маяг”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх үйл ажиллагааны тайлан мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, ирүүлсэн мэдээг нэгтгэж жил бүрийн 2 дугаар сарын 1-ны дотор Эрүүл мэндийн яамны Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөлд хүргүүлж байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д даалгасугай.
3. Тухайн жилд Монгол улсад ашиглаж болох ахуйн хортон, шавж мэрэгч устгалын болон ариутгал халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалтыг батлах хамтарсан тушаалд бүртгэгдсэн бодисыг оруулж байхыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат)-д даалгасугай.
4. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар)-т үүрэг болгосугай.
5. Энэхүү журам батлагдсантай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2011 оны 366 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

001855

4

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 1
дүгээр сарын 02 өдрийн 05 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ
БОДИСЫГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ ЖУРАМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “Эрүүл мэндийн тухай хууль”, “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-д нийцүүлэн нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх дотоодын болон импортын ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг Монгол улсад бүртгэх, чанарын баталгаатай байдлыг хангах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.


1.2. ЭМЯ-ны Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) нь эдгээр бодисыг улсын бүртгэлд бүртгэх, сунгах, хүчингүй болгох асуудлаар шийдвэр гаргана.

1.3. ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс нь (цаашид “ажлын алба” гэх) ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисын бүртгэлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна.

1.4. Ажлын алба нь улсын бүртгэлд бүртгүүлэх материалыг хүлээн авч бүртгэн, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын асуудал хариуцсан мэргэжлийн зөвлөлийн (цаашид “мэргэжлийн зөвлөл” гэх) дүгнэлт, ЭМЯ-ны Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гэрчилгээ олгох, мэдээний санд оруулах, холбогдох байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагааг хариуцна.

1.5. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх чиглэлээр үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай шавж, мэрэгч, нян, вирус, тархвар, хор судлаач зэрэг нарийн мэргэжлээр мэргэшсэн эмч, биологич, химич, эрүүл ахуйч мэргэжилтэй хөндлөнгийн шинжээчдээс бүрдсэн мэргэжлийн зөвлөл байгуулж холбогдох баримт бичиг, туршилт судалгаа, олон улсын байгууллагын зөвлөмж зэргийг үндэслэн мэргэжлийн дүгнэлт гаргана.

ХОЁР. АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН БҮРТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА



2.1. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын бүртгэлд дараах бодисыг үйлдвэрлэгч болон гарал үүслийн улс тус бүрээр бүртгэнэ. Үүнд:

2.1.1. Шинээр хэрэглэх ахуйн шавж, мэрэгч устгах бодис

2.1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинээр хэрэглэх ариутгах, халдваргүйжүүлэх бодис

2.1.3. Ахуйн нөхцөлд шинээр хэрэглэх ахуйн шавжаас хамгаалах бодис (арьсны түрхлэг, цацлага, шавьж үргээгч ялтас г.м.)

2.2. Улсын бүртгэлд бүртгүүлэх ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодис нь дор дурьдсан шаардлага хангасан байна. Үүнд:

2.2.1. Олон улсын байгууллагаас зөвлөмж болгосон байх (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага г.м)

2.2.2. Экспортлогч улсын эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан тухайн бодисын сертификаттай байх;

2.2.3. Экспортлогч улсын эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан лабораторийн шинжилгээний бичигтэй байх;

2.2.4. Шошго, хэрэглэх заавар нь албан ёсны баталгаажсан монгол орчуулгатай байх;


2.2.5. Экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас тухайн улсдаа 3-аас доошгүй жил хэрэглэгдэн сөрөг нөлөөгүй болохыг баталгаажуулсан албан ёсны бичигтэй байх;

2.2.6. Бодисыг хэрэглэх арга аюулгүй ажиллагааны заавартай байх.

ГУРАВ. АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Бүртгүүлэхийг хүсэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын

болон ариутгал халдваргүйтгэлийн бодисыг турших "ашиглах журам" -д дурдсанаас гадна дараах бичиг баримтыг ажлын албанд ирүүлнэ. Үүнд:



3.1.1. Бүртгүүлэх өргөдөл

3.1.2. Үйлдвэрлэгч байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбар

3.1.3. Үйлдвэрлэгчийн танилцуулга

3.1.4. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын хаяглалт, дагалдах мэдээлэл, хэрэглэх заавар

3.2. Монгол улсад үйлдвэрлэсэн ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодис бүртгэхэд нэмэлтээр ариутгах халдваргүйжүүлэх бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.

3.3. Факс, цахилгаан шуудангаар илгээсэн, тамга тэмдэггүй бичиг баримтыг шаардлага хангахгүйд тооцно. Ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг бүртгүүлэгч байгууллага хариуцна.

3.4. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын бүртгэлийн бичиг баримтыг ажлын алба хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж, мэргэжлийн зөвлөл нь ажлын 21 хоногийн дотор дүгнэлт гарган ажлын албанд буцааж ирүүлнэ.

3.5. Ажлын алба нь мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ажлын 5 хоногт багтаан зөвлөлийг хуралдуулан хурлын шийдвэрийг үндэслэн улсын бүртгэлд хоёр жилийн хугацаагаар бүртгэж гэрчилгээг ажлын 5 хоногийн дотор олгоно.


3.6. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг бүртгэхгүй, буцаасан шийдвэр гарсан тохиолдолд тухайн байгууллагад албан бичгээр ажлын 5 хоногийн дотор шийдвэрийг хүргүүлнэ.

3.7. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын тухай мэдээний сан, баримт бичгийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг ажлын алба хариуцна.

3.8. Улсын бүртгэлд бүртгэсэн ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын бүртгэлийн баримт бичгийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах бөгөөд тэдгээрийн бүртгэлийг хөтөлж баримт бичгийг архивын тухай хуулийн дагуу архивлана.

7

**ДӨРӨВ. АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН БҮРТГЭЛИЙГ СУНГАХ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**



4.1. ЭМЯ-ны Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөл нь ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын бүртгэлийг сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

4. 2. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын улсын бүртгэлийг сунгахад дараах материал бүрдүүлнэ:

4.2.1. Байгууллагын албан бичиг

4.2.2. Тухайн химийн бодисыг лабораторид шинжлүүлсэн шинжилгээний дүн

4.2.3. Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт

4.3. Бүртгэгдсэн ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын бүртгэлийг дараах тохиолдолд мэргэжлийн эрх бүхий байгууллагын санал, дүгнэлт, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хүчингүй болгоно. Үүнд:

- хэрэглэх явцад хортой үйлчлэл илэрсэн

-зах зээлд хуурамчаар их хэмжээгээр түгээгдсэн талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан

-үйлдвэрлэлийн технологи хоцрогдсоноос чанарын шаардлага хангахгүй болсон

- олон улсын хэмжээнд хэрэглэхийг хориглосон.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 1
дүгээр сарын 02 өдрийн 03 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ
БОДИСЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Соёмбо

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
MINISTRY OF HEALTH OF MONGOLIA

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

INSECTICIDE, RODENTICIDE, ANTICCEPTIC, DISINFECTANT
REGISTRATION CERTIFICATE

Бүртгэлийн дугаар

Registration number

Бодисын олон улсын нэршил

International name of the chemical

Бодисын худалдааны нэршил

Trade name of the chemical

Үйлчлэгч бодисын нэр, агууламж

Active ingredient and concentration of
chemical

CAS-ын дугаар (пестицид)

CAS number (pesticide)

Бодисын хэлбэр, савлалтын хэмжээ

Chemicals form, package dosage

Хэрэглэх зориулалт

Intended use

Үйлдвэрлэгчийн нэр

Manufacturer name

Гарал үүслийн улс

Country of origin

Бүртгэл ньонысарын өдөр хүртэл хүчинтэй.

Registration valid until _____(day) _____(month) _____(year)

Эрүүл Мэндийн дэд сайд

Vice Minister for Health

(Нэр) (Гарын үсэг) (Тамга)


(Name) (Signature) (Stamp)

Сунгалт
Extension

.....онысарын өдөр хүртэл сунгав.

Extended until _____ (day) _____ (month) _____ (year)

Эрүүл Мэндийн дэд сайд _____ (Нэр) (Гарын үсэг) (Тамга)
Vice Minister for Health (Name) (Signature) (Stamp)



Сунгалт
Extension

.....онысарын өдөр хүртэл сунгав.

Extended until _____ (day) _____ (month) _____ (year)

Эрүүл Мэндийн дэд сайд _____ (Нэр) (Гарын үсэг) (Тамга)
Vice Minister for Health (Name) (Signature) (Stamp)

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 02 өдрийн 13 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН МЭДЭЭНИЙ МАЯГТ

Маягт А

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН БҮРТГЭЛ

20.. оны .. - р сарын.. өдөр

Д/Д	Үйлчлүүлэгч байгууллага		Үйлчилгээ				Хэрэглэсэн химийн бодис		Нэгжид хийсэн тандалт		Тайлбар
	Нэр	Хаяг, утас	Төрөл	Талбай (м ²)	Цаг хугацаа	Нэр	Хэмжээ	Өмнө	Ойох		

Тайлбар: Тухайн байгууллагад хөтлөгдөнө.

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ

[illegible]



.....(аймаг, дүүрэг) ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах,
халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхэлж буй (нэгж)
.....ийн оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

Д/д	Объект		Үйлчилгээ		Үйлчилгээ хийсэн нийт талбай	Тайлбар
	Нэр	Тоо	Төрөл	Тоо		
1	Үйлдвэр		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
2	Эмнэлэг		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
3	Хүнс, удалдаа		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
4	Соёл		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
5	Хүүхдийн байгууллага		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
6	Орон сууц /байр/		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
7	Гэрийн хороо /хашаа/		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
8	Ил задгай талбай		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
9	Төвлөрсөн хогийн цэг		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			

10	Дулааны шугам		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
11	Бусад		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			
12	Дүн		Халдваргүйтгэл			
			Шавжгүйтгэл			
			Мэрэгчгүйтгэл			

20.. оны ..-р сарын .. өдөр

Тайлан гаргасан: ----- /


/

Хянасан: ----- /

/

14

**“Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг улсын
бүртгэлд бүртгэх журам”-д нөлөөллийн шинжилгээ хийсэн тухай
танилцуулга**



2013 оны 1 дүгээр сар 4

2011 онд батлагдсан “Эрүүл мэндийн тухай” хуульд Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан тул Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын “Журам батлах тухай” 1999 оны А/144 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийг 366 дугаар тушаалаар батлуулж бүртгэлийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Эрүүл мэндийн газар хариуцахаар заасан. 2012 оны бүтцийн өөрчлөлтөөр агентлагийн бүтэц өөрчлөгдөн эдгээр бодисын бүртгэл, хяналтыг зохицуулах шаардлага гарсан тул энэхүү тушаалыг шинэчлэн боловсруулж 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн ... тоот тушаалаар баталлаа.

Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмын төсөл бэлтгэх явцад Засгийн газрын 2010 оны 119 тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын дагуу ХЗДХэргийн сайдын 2011 оны 5 дугаар сарын 26-ны 99 тоот тушаалаар батлагдсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу нөлөөллийн шинжилгээ хийсэн болно.

Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам нь:

- Өрсөлдөөнд нөлөөлөхүйц зохицуулалтыг агуулаагүй
- Захиргааны шинэ нэгж, бүтэц бий болгоогүй
- Төлбөр хураамж тогтоогоогүй
- Хүний эрх, эрх чөлөөг аливаа байдлаар хөндөөгүй

учир нөлөөллийн шинжилгээг бүхэлд нь хийх шаардлагагүй гэж үзэж хэсэгчилсэн шинжилгээг хийлээ.

15
“Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу нөлөөллийн шинжилгээг хэсэгчлэн хийхэд хэрэглэх, шалгах асуултын дагуу хийгдсэн ажлыг /хавсралт №1/-ээр гаргаж хавсаргав.



БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР

Хавсралт №1

**Нөлөөллийн шинжилгээг хэсэгчлэн хийхэд хэрэглэх, шалгах асуултын дагуу
хийгдсэн ажил**

д/д	Нөлөөллийн шинжилгээг хэсэгчлэн хийх асуулт	Нөлөөллийн шинжилгээ хийх шаардлага
1	Учирч буй саад, бэрхшээл, асуудлыг тодорхойлсон уу?	ДЭМБ, ХХАБ-н байгууллагаас зөвлөмж болгоогүй ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг хэрхэн бүртгэх талаар асуудал гарч байсан.
2	Учирч буй саад, бэрхшээл, асуудалд нөлөөлж буй гол хүчин зүйлүүд юу вэ?	Манай оронд эдгээр бодисыг шинжлэх лабораторийн хүчин чадал байхгүй тул ДЭМБ, ХХАБ зэрэг олон улсын томоохон байгууллагуудад нарийн туршилт шинжилгээ хийлгэн зөвлөмж болгосон найдвартай бодисыг оруулах нь зүйтэй гэж үзсэн.
3	Төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай юу?тийм бол түүний үндэслэл шаардлага нь юу вэ?	Манай улс ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын 90 орчим хувийг импортлож байгаа нөхцөлд өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай бодисоор тасралтгүй хангахад төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай.
4	Асуудал нь ямар бүлгийн эрх ашиг, сонирхолд хэрхэн нөлөөлж байна вэ?	Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодис ханган нийлүүлэх байгууллага, иргэдийн эрх ашиг сонирхолд нийцсэн байна.
5	Асуудлыг шийдсэнээр ямар зорилго, зорилтод хүрэх вэ?	Монгол улсын ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэгдсэн бодис импортлох, хэрэглэх Эдгээр химийн бодисын чанарын баталгааг хангах Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг хянах боловсон хүчний чадавхи бүрдэх Импортлосон ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын нарийвчилсан мэдээллийн сантай болох.
6	Асуудлыг зохицуулж буй бусад хууль тогтоомж байгаа юу? Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан	“Эрүүл мэндийн тухай” хуулийн 41.1,41.2 заалт Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/144 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын

	шийдвэр байгаа эсэх?	2011 оны 366 тоот тушаал БОАЖСайд, ХХААХҮСайд, ЭМСайдын хамтарсан 2009 оны 63/67/87 дугаар "Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших ашиглах журам"
7	Шийдвэр гарснаар нийгэмд үзүүлэх үр нөлөө нь юу байж болох вэ?	Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын бүртгэлийн асуудал журамлагдана.
8	ЗГ-ын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ын 2.3.2, 2.3.5 дахь заалтуудыг хэрэгжүүлсэн эсэх 2.3.2. Шийдвэрийн төсөл нь тодорхой байгууллага, албан тушаалтны эрхлэх асуудалд хамаарч байгаа бол тэдгээрээс албан ёсоор санал авсан байх 2.3.5. Шийдвэрийн төслийг байгууллагын цахим хуудаст 30-аас доошгүй хоног байрлуулж санал авах	2.3.2. Шийдвэрийн төслийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл (БОАЖЯ, МХЕГ-н Эрүүл мэнд, боловсролын хяналтын хэлтэс, МХЕГ-ын Хилийн мэргэжлийн хяналтын алба, МХЕГ-ын Нэгдсэн төв лаборатори, НЭМХ, ХӨСҮТ, ТББ) оролцсон ажлын хэсэг байгуулан боловсруулсан.